



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/406

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Дүнжингарав дэвжээний бөхчүүдийн бэлтгэл сургуулилттай танилцаж, наадмын сорилго барилдаан зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Сорилго барилдаанд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР